



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№55 /499/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.04.04

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ГАЛЫН ТАРХАЛТЫГ ЗОГСООХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ



ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон "Сэтгэл зүйн бүлэг"-ийнхэн орон нутаг руу хөдөлгөөн үйлдэх явцдаа Төв аймгийн Баянхангай сумын "Цавхангай" хорооллын зам дагуух хувийн орон сууц шатаж байхтай таарч, тэр даруй онцгой

байдлын албанд дуудлага өгч, галын тархалтыг зогсооход дэмжлэг үзүүлсэн байна.

Шатаж байсан хувийн орон сууцтай зэрэгцээд олон аж ахуй нэгж, цайны газар, дэлгүүр байсан учир түймэрдэхээс урьдчилан сэргийлж,

өмч хөрөнгийг нь татан гаргах ажлыг нутгийн иргэдтэй хамтран гүйцэтгэжээ. Нутгийн иргэд гал түймрийг харсан даруйдаа яаралтай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн цэргийн алба хаагчдад талархал илэрхийлжээ.

СЭТГЭЛ ЗҮЙН БҮЛГИЙНХЭН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 256 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА



ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон "Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг" Зэвсэгт хүчний 256 дугаар ангид ажиллалаа.


Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын Цэрэг-иргэний ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ү.Хүрлээгээр ахлуулсан томилгоот бүлэг Зэвсэгт хүчинд алба хааж буй офицер, ахлагч, ажилтан албан хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд нэгтгэл, ангиудад ажиллаж байгаа юм.

Тэд байнгын бүрэлдэхүүнтэй хийсэн сургалтаар "Хамт олны сэтгэл зүй", "Харилцааны сэтгэл зүй", "EQ", "Зөрчил маргааны сэтгэл зүй", "Цаг ашиглах чадварын сэтгэл зүй" 5 төрлийн оношилгоо хичээлийг зохион байгуулж, хичээлийн төгсгөл бүрд оношилгооны тайлал, таниулах сургалт, дасгал ажлыг явуулан, өөрийгөө таньж мэдэх, сул болон давуу чанаруудаа ойлгох, цаашид өөрийгөө хөгжүүлэхэд аль асуудалд түлхүү анхаарах тал дээр заавар, зөвлөгөө өгсөн юм.

Мөн "Стрессээ таньж мэдэх нь", "Өөрийгөө таньж мэдэх нь" зэрэг сэдвээр мэдээлэл хүргэхийн

зэрэгцээ ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг зарим алба хаагчдад өгч, өөрийнхөө сэтгэл зүйг хэрхэн удирдаж чиглүүлэх талаар мэдлэг, сургамж өгсөн үр дүнтэй сургалт болж чадсан юм.

Арга хэмжээний төгсгөлд ангийн захирагч хурандаа Н.Гүрбадам хамт олонсог байх, багаар ажиллах чадвар, бие дааж зөв шийдвэр гаргах, өөрийгөө таних, давуу чанараа хөгжүүлэх, сэтгэл зүйн хямрал үүсвэл түүнийг хэрхэн даван туулах зэрэг ажил, амьдралдаа мөрдлөг болгох олон чухал асуудлаар үнэтэй зөвлөгөө хүргэсэн тус бүлгийнхэнд талархал илэрхийлсэн юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-6	-14

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
41	26

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,510	3,517
EUR	3,825	3,845
CNY	512	514
RUB	44.60	45
JPY	26.60	26.80
KRW	2.69	2.72

ЗУРХАЙ

2023.04.04 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 14

**ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН
ТУУЛАЙ САР
ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХАР
ЛУУ ӨДӨР**

Үс засуулбал:

Эд мал арвидна

Наран ургах, шингэх:

06.25-19.25

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр буян үйл үйлдвээс элзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

**КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 684,140,494

Эдгэрсэн

Нийт: 684,140,494

Нас барсан

Нийт: 684,140,494

Цахим шууданд

ЖЕНДЭРИЙН ОРОН ТООНЫ БУС ДЭД ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



ЗХЖШ-ын дэргэдэх Жендэрийн орон тооны бус дэд зөвлөлийн 2023 оны анхдугаар хуралдааныг энэ сарын 4-ний өдөр зохион байгуулж, ЗХЖШ-ын дэргэдэх Жендэрийн орон тооны бус дэд зөвлөлийн ажиллах журмын төсөл болон дэд зөвлөлийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Зэвсэгт хүчний ХШҮГ-аас хийсэн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн, тодотгол хийх зэрэг асуудлыг хэлэлцэв.

Хуралдааны төгсгөлд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, ЗХЖШ-ын дэргэдэх Жендэрийн орон тооны бус дэд зөвлөлийн дарга хурандаа Ж.Өсөхбаяр Зэвсэгт хүчинд жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, дэд зөвлөлийн үйл ажиллагааг жигдрүүлэхэд цаашид анхаарч ажиллах шаардлагатай чиглэлүүдээр дэд зөвлөлийн гишүүдэд үүрэг даалгавар өглөө.

Хошууч Б.ЗОЛЖАРГАЛ

ХҮЧИТ БӨХИЙН БАРИЛДААНААР...



Зэвсэгт хүчний 353 дугаар ангиас Налайх дүүргийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд үндэсний бөхийн барилдааныг зохион байгууллаа.

Хүчит бөхийн барилдаанд 64 бөх зодоглож үнэн хүчийг үзэн барилдсанаас Хилийн цэргийн 0303 дугаар анги, сумын заан Б.Мөнх-Эрдэнэ түрүүлж, Зэвсэгт хүчний 353 дугаар анги, сумын заан хошууч Э.Энхтүвшин үзүүлэн, Зэвсэгт хүчний 353 дугаар анги, сумын заан ахлах ахлагч Н.Нямжав, 014 дүгээр ангийн сумын заан ахлах ахлагч А.Батзаяа нар тусгай байрт шалгарсан юм. Мөн энэ үеэр үзэгч олныг баясгасан уран барилдаанч бөхийг шалгаруулахад Зэвсэгт хүчний 353 дугаар анги, сумын заан ахлагч Б.Энхбаатар тодорлоо.

“ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦАХИМ ЗӨВЛӨМЖ” СЭДЭВТ УРАЛДААН ЗАРЛАГДЖЭЭ



Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас “Хөдөлмөрийн аюулгүй байдлын цахим зөвлөмж” уралдааныг ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, Төрийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын харьяа нэгтгэл, ангиудад зарлажээ.

Энэ нь хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт, Зэвсэгт хүчинд ажиллагсдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг эрчимжүүлэхэд уралдааны зорилго оршжээ.

Цахим зөвлөмж буюу видео шторк нь 90 секундээс ихгүй

байх бөгөөд хууль дүрэм, журам зааврын хүрээнд утга санаагаа тусгаж, өдөр тутмын үйл ажиллагаа, цэргийн сургалт бэлтгэл, хээрийн гаралт, байлдааны буудлага, жолоодлого (шүхрийн буулт), харуул хоногийн манаа, тусгай томилгоот бүлгээр үүрэг гүйцэтгэх, цэргийн биеийн тамир, цэрэгжлийн болон нийтийн биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцох зэрэг агуулгаар бүтээгдэх юм.

Уралдаанд оролцогчдын бүтээлийг нэгтгэл, ангидаа шалгаруулж, шалгарсан нэг цахим зөвлөмжийг 4 дүгээр сарын 28-ны өдрийн дотор Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэх аж.

БУЛГАН АЙМГИЙН МУЗЕЙН АЖИЛТАН АЛБАН ХААГЧИД МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙД...



Т.Бэхтөр захиралтай Булган аймгийн музейн ажилтан албан хаагчид Монгол цэргийн музейд зочилж, туршлага судлах уулзалтыг зохион байгууллаа. Булган аймгийн музейгээс Монгол цэргийн музейд илгээсэн 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 21 тоот албан бичгийн хүрээнд Монгол цэргийн музей тусгай хөтөлбөрийн дагуу үйл ажиллагааг явууллаа.

Тус хөтөлбөрийн хүрээнд захирал хурандаа Д.Ганзориг музейн ажилтан албан хаагчид болон музейн түүх, үйл ажиллагааг товч танилцуулж өнөөдрийн туршлага судлах арга хэмжээнд амжилт хүслээ. Музейн ерөнхий танилцуулгыг Музей судлал, эрдэм шинжилгээ, сан хөмрөгийн албаны дарга, эрдэм шинжилгээний ахлах ажилтан А.Ганганчимэг танилцуулж, Боловсролын ажилтан-тайлбарлагч Д.Содбилэгт, Олон нийттэй харилцах ажилтан Г.Алтанзул, Лабораторийн эрхлэгч-археологич Л.Гантөмөр нар музейн байнгын үзүүлэгийн танхим, Монгол цэргийн өдөр, зэвсэгт хүчний 102 жилийн ойд зориулсан үзэсгэлэнг дэлгэрэнгүй тайлбарлан үзүүлж музейд сүүлийн үед ашиглаж байгаа дэвшилтэд техник хэрэгсэл, шилэн хорго, тоног төхөөрөмжийн талаар танилцууллаа.

Мөн музейн нээлттэй сан хөмрөг болох уран зураг, зөөлөн эдлэл, туг тамганы сан хөмрөгийг булган аймгийн музейн ажилтан албан хаагчдад танилцуулж туршлага судлууллаа.

Энэхүү арга хэмжээ нь харилцан туршлага судалсан ач холбогдолтой арга хэмжээ боллоо гэж хоёр музейн удирдлага, хамт олон дүгнэлээ. Мөн булган аймгийн музейн захирал Т.Бэхтөр монгол цэргийн музейд дурсгалын зүйл гардууллаа.

“МЭРГЭЖИЛ БҮХЭН САЙХАН” ӨДӨРЛӨГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Олон Улсын инээдмийн баярын өдрийг тохиолдуулан Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын бие бүрэлдэхүүний дунд уламжлал болгон зохион байгуулдаг “Мэргэжил бүхэн сайхан” өдөрлөг амжилттай болж өндөрлөв.

Нийт бие бүрэлдэхүүний дунд харилцан бие биенийхээ ажил үүргийн онцлог шинжийг мэдэрч, хүндэтгэн бахархах, эвсэг, хамтат байдлыг нэмэгдүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилго бүхий тус өдөрлөгт хэлтэс албад өөрсдийн сонголтоор мэргэжлээ сольж, хамтлаг болон гоцлол байдлаар дуу, бүжиг, хөгжмийн бүтээлээс сонгон бэлтгэж өрсөлдсөн юм.

Идэвх, санаачлага, инээд хөөр, дэгжин хэв маяг, гэнэтийн зүйлсээр дүүрэн тус өдөрлөгийн Шилдэг хамт олны төрөлд тэргүүн байрыг Эстрад симфони найрал хөгжмийн албаны “Acapella” хамтлаг “Дэлхийн шилдэг киноны дуунууд” бүтээлээр, дэд байрыг Үндэсний найрал хөгжмийн албаны хөгжимчид “Тогооч цэргийн наргиант бүжиг” бүтээлээр, гутгаар байрыг Найрал дууны албаны “Найрал Хү” хамтлаг “Чонон сүлд” бүтээлээр тус тус шалгарлаа.

Мөн Шилдэг уран бүтээлчийн тэргүүн байрт МУСТА Хөгжимчин Д.Өлзийбаяр “Nessus dorma” бүтээлээр, дэд байрт бүжигчин Ч.Чинбат “Хайр” бүтээлээр, гутгаар байрт маркетингийн менежер Н.Энхмаа “Хүрээ хүүхнүүд” бүтээлээр тус тус шалгарч хамт олноо хошууцллаа.

Энэхүү өдөрлөгийг Хөгжмийн зохиолч, Үндэсний хөгжмийн удирдаач, МУСТА О.Эрдэнэцог, Бүжгийн албаны ахлах бүжигчин МУСТА Э.Мөнхтөр, Гоцлол хөгжимчин МУСТА Н.Мөнгөн-Очир нар шүүн тунгаан явууллаа.

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА

Дарга дэд хурандаа
САЙНБОЛДЫН
УУГАНБАЯР

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний
Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” редакц
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Soymbob@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)